



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 492

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, 4 нэрийн, нийт 38,247,795.28 (гучин найман сая хоёр зуун дөчин долоон мянга долоон зуун ерэн таван төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 34,751,746.63 (гучин дөрвөн сая долоон зуун тавин нэгэн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн бүрэн эрхт төлөөлөгч Б.Баттөмөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 20245 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002274

22-r\_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 10 дугаар сарын ..... ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

"ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Истана /Istana Ssangyong/, улсын дугаар 00-52 ХӨА, микробус, арлын дугаар КРДАВ5Е81ХР083582	1999	ш	1	13,000,000.00	13,000,000.00	13,000,000.00	-	1,500,000.00
2	Зил-130, улсын дугаар 23-72 ХӨА, ачааны, арлын дугаар 2842480	1989	ш	1	5,300,000.00	5,300,000.00	5,300,000.00	-	2,000,000.00
3	Мицубуши страда /Mitsubishi Strada/, улсын дугаар 03-43 ХӨВ, суудлын, арлын дугаар К741000515	1998	ш	1	16,100,000.00	16,100,000.00	14,620,022.19	1,479,977.81	2,000,000.00
4	УАЗ-220692 фургон, улсын дугаар 44-91 ХӨУ, арлын дугаар 90202780	2009	ш	1	3,847,795.28	3,847,795.28	1,831,724.44	2,016,070.84	2,100,000.00
	Нийт дүн				38,247,795.28	38,247,795.28	34,751,746.63	3,496,048.65	7,600,000.00
						(гучин найман сая хоёр зуун дөчин долоон мянга долоон зуун ерэн таван төгрөг хорин найман мөнгө)	(гучин дөрвөн сая долоон зуун тавин нэгэн мянга долоон зуун дөчин зургаан тегрөг жаран гурван мөнгө)	(гурван сая дөрвөн зуун ерэн зургаан мянга дөчин найман төгрөг жаран таван мөнгө)	(долоон сая зургаан зуу)